ДОРНОД АЙМАГ
БАЯНТҮМЭН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 17 өдөр Дугаар 12/01 Цагаан дэрс

Г ᄀ

Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, хууль зүй, дотоод хэргийн сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны "Журам батлах тухай" А/173, А/251, А/380 дугаар тушаалын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт шатанд илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийг нөхөн сэргээхэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх зорилгоор сумын хамтарсан багийн бүрэлдэхүүнийг чиг үүргийн дагуу хавсралтаар шинэчлэн байгуулсугай.

2.Хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөв, сумын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган, бусад хөтөлбөр төсөлд хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээг авч ажиллахыг Хамтарсан багийн ахлагч, Засаг дарга (П.Гунгаацэрэн)-д үүрэг болгосугай..

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 04/06 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай..

ХУРЛЫН ДАРГА Ж. БАТЧУЛУУН

2105001023

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 12/01 дүгээр тогтоолын
хавсралт

ХАМТАРСАН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Хамтарсан багийн ахлагч

Засаг дарга

Гишүүн:

Цагдаагийн хэсгийн төлөөлөгч

Эрүүл мэндийн төвийн их эмч

Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Цэцэрлэгийн арга зүйч

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн

Багийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга:

Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан